

БАТЛАВ

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Д.МӨНХБААТАР

2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

**“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ-ЫН 2026 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030 он/, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон байгууллагын үйл ажиллагааны онцлог, авлигын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2026 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулав.

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хариуцах хэлтэс, нэгж, албан тушаалтан
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбар зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэнэ.	I-IV улиралд	Олон нийтэд хүргэсэн мэдээ, мэдээллийн тоо	Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байна.	Сургалт, судалгаа, мэдээллийн хэлтэс; Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
		1.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлигын эсрэг арга хэмжээ, аян, өдөрлөгийг байгууллагын онцлогт тохируулан хамтран зохион байгуулна.	I-IV улиралд	2-оос доошгүй удаа	Авлигын эсрэг арга хэмжээг дэмжиж, хамтран ажилласан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс

	хүртээмжийг нэмэгдүүлэх	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар болон цахим буланг тогтмол ажиллуулна.	I-IV улиралд	Шинэчилсэн мэдээллийн тоо	Мэдээллийг тухай бүр шинэчилж, иргэд олон нийтэд нээлттэй хүргэсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах авлигын эсрэг анхан болон давтан сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулна.	I-IV улиралд	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Холбогдох албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
		2.2. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн нэгжтэй хамтран байгууллагын удирдлага, албан хаагчдад зориулсан зорилтот сургалт зохион байгуулна.	I-IV улиралд	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх, хүргүүлэх	3.1. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, албан бичиг, мэдэгдэл, зөрчил арилгуулах чиглэлийн хүрээнд холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хариуг хугацаанд нь хүргүүлнэ.	I-IV улиралд	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Арга хэмжээг хэрэгжүүлж, хариу тайлан, мэдэгдлийг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс; Холбогдох хэлтэс, нэгжүүд
		3.2. Байгууллагын үйл ажиллагаанд хийх тандалт, дүн шинжилгээ, судалгаанд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг Авлигатай тэмцэх газарт тухай бүр гарган хүргүүлж, хамтран ажиллана.	I-IV улиралд	Хүргүүлсэн мэдээллийн тоо	Шаардлагатай баримт бичиг, мэдээллийг бүрэн гаргаж хүргүүлсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс; Холбогдох хэлтэс, нэгжүүд

4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилгыг өрнүүлэх	4.1. Байгууллагаас иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээ, хэлцэлд авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг тусгаж хэвшүүлнэ.	I-IV улиралд	Батлагдсан гэрээний тоо	Гэрээ, хэлцэлд холбогдох заалтыг тусгасан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс; Холбогдох хэлтэс, нэгжүүд
		4.2. Албан тушаалтнуудад ХАСХОМ, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах талаар заавар, зөвлөмжийг тухай бүр хүргэж, хэрэгжилтэд хяналт тавина.	I-IV улиралд	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Албан тушаалтнуудыг мэдээллээр хангаж, холбогдох ажиллагааг зохион байгуулсан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
		4.3. Удирдах албан тушаалтны шударга байдал, ёс зүй, хариуцлагын манлайллыг дэмжих чиглэлээр дотоод мэдээлэл, санамж, хэлэлцүүлэг зохион байгуулна.	II-IV улиралд	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Удирдлагын манлайлал, оролцоо нэмэгдсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах	5.1. Байгууллагын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй авлигын эрсдэл, ашиг сонирхлын зөрчил үүсэх боломжтой чиг үүрэг, процессыг тодорхойлж, эрсдэлийг бууруулах зохион байгуулалтын болон цахимжуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 5.2 Барилга байгууламжийн зураг төслийн магадлал зохион байгуулах хэлтсийн хэрэгжүүлж байгаа цахимжуулах үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлнэ. 5.3 Албан хэрэг хөтлөлт түүний хэрэгжилт дээр хяналт тавих	I-IV улиралд	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, эрсдэлийг бууруулах чиглэлээр тодорхой үр дүнд хүрсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс; Холбогдох хэлтэс, нэгжүүд

6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	6.1. Ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын албан ёсны цахим хуудсанд тухай бүр байршуулж, иргэд олон нийтэд нээлттэй мэдээлнэ.	I-IV улиралд	Байршуулсан зарын тоо	Сул орон тооны мэдээллийг тухай бүр ил тод байршуулсан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
		6.2. Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуульд заасан хугацаанд албан ёсны цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийт танилцах боломжийг бүрдүүлнэ.	I-IV улиралд	Байршуулсан мэдээллийн тоо	Хуульд заасан мэдээллийг хугацаанд нь цахим хуудсанд байршуулсан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс; Санхүү, бүртгэлийн асуудал хариуцсан нэгж; Холбогдох хэлтэс, нэгжүүд

ЗАХИРГАА, АЖ АХУЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА
 БОЛОВСРУУЛСАН: ЗАХИРГАА, АЖ АХУЙН
 ХЭЛТСИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
 МЭРГЭЖИЛТЭН



Т.БААСАНЦОГТ



Э.БИЛГҮҮН